



БОЛОВСРОЛЫН САЙД
П.НАРАНБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.09.26 № 44

Хуулийн хэрэгжилт ирүүлэх тухай

Улсын Их Хурлын даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 114 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 21 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилттэй танилцах, бүх шатны сургуулийн багшийн хомсдолыг бууруулах, үнэлэмжийг дээшлүүлэх болон төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах зорилготой ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт заасны дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнасан.

Боловсролын ерөнхий хуулийн хүрээнд эрх олгосон 37 хэсэг, заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг гаргахад 30 хэсэг, заалтын тайланг ирүүлснээс 21 хэсэг, заалтын хэрэгжилт бүрэн хангагдсан байна. Харин 9 хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тооцоо судалгаа хийх, бэлтгэл ажлыг хангах болон боловсруулалтын шатны ажлууд хийгдэж байгаа тул хэрэгжилт 0-30 хувьтай буюу "хэрэгжих шатандаа" байна гэж дүгнэсэн байна. Мөн ерөнхий хуулийн хүрээнд 21 журам батлагдаж, хэрэгжилт хангагдсан хэдий ч хэрэгжилт 56.7 хувьтай гэж дүгнэсэн байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1. Боловсролын ерөнхий хуулийн хүрээнд эрх олгосон 37 хэсэг, заалтын хэрэгжилт;

2. Боловсролын ерөнхий хуульд батлахаар заасан дүрэм, журмын жагсаалт болон хэрэгжилтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж ирүүлнэ үү.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн;

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ж.ГАЛБАДРАХ



2025000067